



ИРГЭНИЙ МЭДЭЭЛЭЛ INDIVIDUAL'S INFORMATION

Эцэг/эх-н нэр/Surname: _____ Нэр/Name: _____ Регистр №: _____

БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ ORGANISATION'S INFORMATION

Байгууллагын нэр: _____ Байгууллагын регистр: _____
Organisation: _____ Organisation's register №: _____

ДАНС НЭЭХ, НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ ACCOUNT SERVICE

ДАНС НЭЭХ OPEN NEW ACCOUNT

Харилцах / Current account Тусгай нөхцөлтэй харилцах хоног / Special term deposit account

ДАНСНЫ НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ ACCOUNT ADDITIONAL SERVICE

Дансны хуулга, тодорхойлолт гаргуулах /To take account statement or definition

Захиалгат шилжүүлэг /Requested transaction

Шилжүүлэг хийх дүн /Amount	
Дансны дугаар /Account number	
Давтамж /Frequency	<input type="checkbox"/> Долоо хоног бүр /гарга/ <input type="checkbox"/> Сар бүр-нд <input type="checkbox"/> Жилд-нд

Хүлээн авагчийн мэдээлэл Receiver information	Банк/Bank :
	Дансны дугаар/Account number :
	Нэр/Name :

Данс хаах / Close account

КАРТ, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ CARD AND ONLINE SERVICE

ИНТЕРНЭТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ INTERNET BANKING SERVICE <https://ebank.ckbank.mn>

Хуулга харах/Statement

Хамтран эзэмшдэг данс/Connect co-owned account

Гүйлгээ хийх (Төлбөртэй) /Transaction

Нууц үгийнэ төхөөрөмж шинэчлэн авах /Renew vasco

Бүх дансыг холбох /Connect all accounts

Гүйлгээний дүнгийн хязгаар өөрчлөх / Change transaction limit

Сонгосон дансуудыг холбох /Connect chosen accounts

Дансны дугаар /Account number

Хязгаарлалт / Limit	Валют/Currency	Дүн/Amount
НҮТ-гүй /Иудаагийн / Without Vasco /once/		
НҮТ-тэй /Иудаагийн/ With Vasco /once/		
Өдрийн дээд хэмжээ. Maximum limit of a day.		

Гарын үсэг зурах эрх бүхий ажилтны мэдээлэл шинэчлэх / Update authorized person to sign:

1-р гарын үсэг/1st signature :

Эцэг/эх-н нэр/Surname : _____ Нэр/Name : _____ Регистр №: _____

Утас/Phone : _____ Имэйл хаяг/E-mail address: _____

2-р гарын үсэг/2nd signature :

Эцэг/эх-н нэр/Surname : _____ Нэр/Name : _____ Регистр №: _____

Утас/Phone : _____ Имэйл хаяг/E-mail address: _____

Хаяг, холбоо барих утас өөрчлөх / Change address and contact

Хаяг/ Address

Утас/ Phone

Гэрээ цуцлах / Termination

МЕССЭЖ МЭДЭЭ SMS INFO

Шимтгэл суутгах данс /Мессэж бүрт 50₮/
MNT account number, charged 50₮ for a SMS

Гар утасны дугаар / Cell phone number

Дансны дугаар Account number	Орлого Income	Зарлага Expense	Дүн / Amount
	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	-с дээш
	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	-с дээш
	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	-с дээш

ТӨЛБӨРИЙН КАРТ PAYMENT CARD

Карт захиалах/Order new card Энгийн /Classic Цалингийн /Salary Тэтгэврийн /Pension Алтан /Gold Платинум /Platinum

Картын нэмэлт үйлчилгээ Гэмтэлтэй/гээгдсэн карт дахин захиалах /ReOrder card

Card additional service

Пин код дахин захилах /ReOrder card

Интернэт пин код идэвхжүүлэх /Card internet pin code

Гүйлгээний лимит нэмэгдүүлэх/Increase card transaction limit 5 сая ₮ 15 сая ₮ сая ₮

Карт хаах (Close card)

НУУЦ ХАРИУЛТ: Та картаа хаяж үрэгдүүлсэн үед картаа хаалгах болон онлайн үйлчилгээ авахад банкны үйлчилгээний утасны дугаар руу залгаж үйлчилгээ авахад банкны ажилтан таны нууц асуултыг асуух бөгөөд нууц үгээ зөв хариулж картын жинхэнэ эзэмшигч гэдгээ нотлох тул өөрийн нууц үгийн нууцлалыг хариуцна уу.

(CONFIDENTIALITY: In case of a lost card, immediately inform the bank in order to block fraudulent transactions. To process your request, you must provide the bank officer with the code word indicated above. You will also provide this code word when making inquiries regarding your account in order to prove your identity)

Нууц асуулт/Secret question : _____

Нууц хариулт/Secret answer : _____

тамга / stamp

Хүсэлт гаргагчийн баталгаат гарын үсэг: Authorized signature:

1-р гарын үсэг / 1st signature	2-р гарын үсэг / 2nd signature

БАНКНЫ ХЭРЭГЦЭЭНД BANK USE ONLY

Салбар _____ Бүртгэсэн ажилтан _____ /
Харилцагчийн CIF код _____ Бүртгэсэн огноо _____ / _____ /
НҮТ / Васко сериал _____ Хянасан _____ /



ЦАХИМ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

20оны - р сарын - ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү Цахим банкны үйлчилгээний гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г нэг талаас Чингис Хаан Банк (цаашид "Банк" гэх), нөгөө талаас (цаашид "Харилцагч" гэх) нар (хамтад нь "Талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

1.1. Энэхүү гэрээгээр Харилцагч нь интернэт холболт бүхий мэдээллийн технологи, харилцаа холбооны төхөөрөмжийг ашиглан Банкн дэх өөрийн данснаас гүйлгээ, төлбөр тооцоо хийх, бусад үйлчилгээ авах, Банк нь уг төлбөр тооцоог гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

Хоёр. Цахим банкны үйлчилгээний ерөнхий нөхцөл

- 2.1. Харилцагч нь цахим банкны үйлчилгээний үндсэн нөхцөлтэй танилцаж, хүлээн зөвшөөрсний үндсэн дээр Банкн дэх үйлчилгээ авах хүсэлтийг холбогдох маягтын дагуу үнэн зөв гаргаж, үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулна.
- 2.2. Банк нь цахим банкны үйлчилгээнд ашиглах нэвтрэх нэр болон нууц үг, гүйлгээний нууц үг, нууц үгийн төхөөрөмж (цаашид "НҮТ" гэх)-ийг Харилцагчид олгоно. Нэвтрэх нэр, нууц үг, НҮТ нь Банкн дэх Харилцагчийн мөнгөн хөрөнгийг захиран зарцуулахад хэрэглэгдэх албан ёсны баталгаат тэмдгийн дардас, мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээдийн баталгаат гарын үсэгтэй адил хүчинтэй байна.
- 2.3. Харилцагч нэвтрэх нэр болон нууц үг, гүйлгээний нууц үг, НҮТ-ийг ашиглан цахим банкны үйлчилгээгээр гүйлгээ хийсэн тохиолдолд Банк уг гүйлгээ болон түүний шимтгэлийн дүнгээр харилцагчийн данснаас зарлага гаргаж, холбогдох төлбөр тооцоог гүйцэтгэнэ.
- 2.4. Харилцагч "Банкны үйлчилгээний хураамж, хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл"-ийн дагуу цахим банкны үйлчилгээний жилийн хураамж, НҮТ-ийн төлбөр болон гүйлгээний шимтгэлийг төлнө. Цахим банкны хэрэглэгч банкны бүтээгдэхүүнийг онлайн аар захиалж болох бөгөөд онлайн захиалга өгснөөс хойш ажлын 3 хоногийн дотор үйлчилгээ үзүүлэх эсэхийг шийднэ.

Гурав. Банкны эрх, үүрэг

- 3.1. Банк дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 3.1.1. Цахим банкны үйлчилгээг тасралтгүй, шуурхай, найдвартай зохион байгуулах;
 - 3.1.2. Цахим банкны үйлчилгээний талаарх заавар, зөвлөмжөөр Харилцагчийг бүрэн хангах;
 - 3.1.3. Энэхүү гэрээний нөхцөлийн дагуу Харилцагчийн төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэх;
 - 3.1.4. Харилцагчийн хүсэлтээр Харилцагчийн дансны тодорхойлолт болон цахим үйлчилгээгээр дамжуулан хийгдсэн гүйлгээний баримт, хуулгыг гаргаж өгөх;
 - 3.1.5. Харилцагчийн данс болон гүйлгээний талаарх мэдээллийг Монгол улсын хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, нууцлалыг хадгалах;
 - 3.1.6. "Банкны үйлчилгээний хураамж, хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл"-ийн өөрчлөлтийг Харилцагчид тухай бүр мэдэгдэх.
- 3.2. Банк дараах эрх эдэлнэ. Үүнд:
 - 3.2.1. Цахим банкны үйлчилгээний шимтгэл, хураамжийг "Банкны үйлчилгээний хураамж, хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл"-д заасны дагуу Харилцагчийн данснаас суутгах, дансны үлдэгдэл шимтгэл, хураамж төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд гүйлгээ хийхээс татгалзах;
 - 3.2.2. Харилцагч цахим банк болон смарт банкны үйлчилгээ ашиглах явцад 10 минутын дотор функцний үйлдэл хийгээгүй тохиолдолд Харилцагч болон Банкний эрсдэлээс хамгаалах зорилгоор тухайн програмаас автоматаар гаргах;
 - 3.2.3. Харилцагч нэвтрэх нууц үгийг 3 удаа буруу оруулсан тохиолдолд Цахим банкны үйлчилгээний эрх хаагдана;
 - 3.2.4. Харилцагч өөрийн нэвтрэх нэр болон нууц үг, гүйлгээний нууц үг, НҮТ-ийг бусад дамжуулсан, задруулсан, алдсны улмаас түүнд учирсан аливаа хохирлыг Банк хариуцахгүй;
 - 3.2.5. Харилцагч гэрээгээр хүлээнэ үүргээ биелүүлээгүй бол гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, үйлчилгээний эрхийг хаах;
 - 3.2.6. Харилцагч энэхүү гэрээгээр тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд Харилцагчийн гүйлгээг хийхгүй байх;
 - 3.2.7. Харилцагчийн мөнгөн хөрөнгийг гадны халдлагаас хамгаалах үүднээс сэжигтэй гэж үзсэн гүйлгээг түр түдгэлзүүлэх, Харилцагчаар баталгаажуулах.

Дөрөв. Харилцагчийн эрх, үүрэг

- 4.1. Харилцагч дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 4.1.1. Цахим банкны үйлчилгээний зааврыг хатуу баримтлах, өөрийн мөнгөн хөрөнгийн аюулгүй байдлыг хангах;
 - 4.1.2. Цахим банкны үйлчилгээнд шинээр бүртгүүлэхэд Банкнаас илгээсэн, мөн Банкн дэх хүсэлт гарган шинэчлүүлсэн нэвтрэх нууц үг болон гүйлгээний нууц үгийг үйлчилгээнд анх нэвтрэхийн дараа заавал сольж ашиглах;
 - 4.1.3. Нэвтрэх нууц үг, гүйлгээний нууц үг, НҮТ-ийг бусад дамжуулахгүй байх, нууцлалыг хадгалах, задруулахгүй байх, эдгээрийн нууцлалыг хадгалаагүйгээс үүсэн гарсан аливаа хохирлыг хариуцах;
 - 4.1.4. Нэвтрэх нууц үг болон гүйлгээний нууц үгээ бусдад дамжуулсан, задруулсан, алдсан, НҮТ болон гар утсаа гэсэн, хулгайд алдсан тохиолдолд Банкны 317178 дугаарын утас, ebank@ckbank.mn цахим хаягт Банкн дэх бүртгэлтэй өөрийн цахим хаягаас цахим шуудан илгээх эсвэл Банкн дэх биеэр ирж мэдэгдэн үйлчилгээний эрхээ түр халгах, ийнхүү мэдэгдээгүйн улмаас үүсэх аливаа хохирлыг бүрэн хариуцах;
 - 4.1.5. Банк Харилцагчийн нэвтрэх нэр болон нууц үг, гүйлгээний нууц үг, НҮТ-ийн нууц дугаарын талаарх мэдээллийг Харилцагчаас авахаар шаардахгүй тул Банктай ижил нэр, вэб хаягаас хандаж байгаа аливаа хүсэлтэд мэдээллээ өгөхгүй байх, үүнээс үүдэн гарсан хохирлыг бүрэн хариуцах, ийм хүсэлтийн талаар Банкн дэх нэн даруй мэдэгдэх;
 - 4.1.6. Нэвтрэх нууц үгээ 3 сар тутамд сольж хэвших;
 - 4.1.7. Цахим банкны үйлчилгээний эрхээ өөр этгээдэд шилжүүлэх шаардлага гарсан тохиолдолд Банкн дэх хандаж, албан ёсны итгэмжлэл, баримт бичгээр шилжүүлэх;
 - 4.1.8. Цахим банкны үйлчилгээг ашиглаж дууссан даруйдаа тухайн програмаас гарч байх, энэ үүргийг биелүүлээгүйгээс болж үүдэн гарах аливаа хохирлыг хариуцах;
 - 4.1.9. Цахим банкны үйлчилгээнд ашиглаж буй компьютер болон гар утасны интернэтийн төлбөрийг хариуцах;
 - 4.1.10. Цахим банкны үйлчилгээгээр дамжуулан хийсэн гүйлгээ бүрийг дансны хуулгатай тухай бүр тулгаж шалгах;
 - 4.1.11. Цахим банкны үйлчилгээнд гүйлгээний мэдээллийг үнэн зөв оруулан, нягталж шалгасны үндсэн дээр уг гүйлгээг хийх;
 - 4.1.12. Цахим банкны үйлчилгээний шимтгэл, хураамж төлөх.
- 4.2. Харилцагч дараах эрх эдэлнэ. Үүнд:
 - 4.2.1. Цахим банкны үйлчилгээтэй холбоотой байх, хүсэлтийг Банкн дэх гаргах;

<https://ebank.ckbank.mn>

- 4.2.2. Цахим банкны үйлчилгээгээр дамжуулан ийн данс хооронд, Банкны салбар, банк хооронд, гадаад гуйвуулаа, цалингийн гүйлгээ, арилжааны хэлцэл зэрэг бэлэн бус гүйлгээ хийх;
- 4.2.3. Өөрийн хийсэн гүйлгээний баримт, хуулгыг авах;

Тав. Гүйлгээ, төлбөр тооцоо

- 5.1. Харилцагч гүйлгээний цахим төлбөрийн даалгаврын өгөгдлийг бүрэн шивсэн, данс дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь тухайн гүйлгээний дүн болон холбогдох шимтгэл, хураамжийг төлөхөд хүрэлцэж байгаа тохиолдолд гүйлгээ хийгдэнэ.
- 5.2. Хоёр өөр төрлийн валютын дансны хооронд гүйлгээ хийх тохиолдолд тухайн өдрийн Банкнаас зарласан ханшийн шатлалын дагуу бэлэн бус ханш байна.
- 5.3. Цахим банкны үйлчилгээгээр хийгдэх гүйлгээ, төлбөр тооцооны аюулгүй байдлыг хангах үүднээс Банк нэг өдөрт, мөн нэг удаа хийх гүйлгээний дүнгийн дээд хэмжээнд дараах хязгаарлалтуудыг тогтооно. Үүнд:

№	Хязгаарлалт	Ирээн	Байгууллага
1	Нууц үгийн төхөөрөмжгүй	3,000,000.00	0
2	Нууц үгийн төхөөрөмжтэй	15,000,000.00	30,000,000.00
3	ӨФӨРИН ДЭЭД ХЭМЖЭЭ	15,000,000.00	100,000,000.00

- 5.4. Тухайн өдрийн тасалбар болгох хугацаанд оруулсан гүйлгээ нь тухайн ажлын өдөрт хийгдсэн тооцогдох бөгөөд бусад хугацаанд хийгдсэн гүйлгээ нь дараагийн ажлын өдөрт хийгдэнэ. Энэ хугацаанд хүлээлийн горимд байна.

Д/д	Гүйлгээний төрөл	Тасалбар болгох хугацаа
1	Өөрийн данс хооронд / Валют арилжаа Банк дотор	00:00-23:59 00:00-23:59
2	Банк хооронд (1 сая ₮ хүртэл дүнтэй) Банк хооронд (1 сая ₮-өөс дээш дүнтэй)	00:00-23:59 00:00-15:59
3	Гадаад гуйвуулаа	00:00-16:59

- 5.5. Банк хооронд болон гадаад гуйвуулгын гүйлгээ хийх өдөр нь ажлын бус өдөр таарвал дараагийн ажлын өдөрт хийгдэнэ.
- 5.6. Тухайн гүйлгээ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж болон Банкны бодлого, журмын дагуу эрсдэлтэй буюу сэжигтэй гүйлгээнд тооцогдож байгаа, эсхүл тухайн дансанд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу бүтээмжлэл тавигдсан тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.
- 5.7. Цахим банкны үйлчилгээгээр хийгдсэн гүйлгээтэй холбоотой маргааныг гүйлгээ хийгдсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор Банкн дэх бичгээр гаргах боломжтой. Энэ хугацаанаас хэтэрсэн маргааныг Банк хүлээн авахгүй.

Зургаа. Гэрээний хугацаа ба гэрээ цуцлах

- 6.1. Талууд харилцан тохиролцож, энэхүү гэрээг нэг жилийн хугацаагаар байгуулж байна.
- 6.2. Гэрээний хугацаа дуусахад талууд цуцлах санал гаргаагүй бол харилцагчийн харилцах данснаас шимтгэл, хураамж суутгагдаж, нэг жилийн хугацаагаар сунгагдсан тооцогдох ба цаашид хэдэн ч удаа сунгагдаж болно.
- 6.3. Харилцагч гэрээг цуцлах хүсэлтээ бичгээр гаргасан тохиолдолд, эсвэл холбогдох хууль, тогтоомжийн дагуу данс хаасан шийдвэрийн хуулбарыг үндэслэн гэрээг цуцална.
- 6.4. Банк эсвэл Харилцагчийн аль нэг талын санаачилгаар үйлчилгээний эрхийг зогсоосноор энэхүү гэрээг дуусгаар болсон тооцоо.

Долоо. Хариуцлага

- 7.1. Талуудын аль нэг нь гэрээг зөрчсөнөөс нөгөө талдаа учирсан бодит хохирол, зардлыг бүрэн хариуцна.
- 7.2. Гэрээ цуцлагдсан, дуусгавар болсон тохиолдолд гэрээг хүчин төгөлдөр байх үед үүссэн төлбөр тооцооны эрх, үүрэг бүрэн биелэгдэж буюу хуртэл хугацаанд гэрээний зохицуулалт нь талуудын хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 7.3. Харилцагч гэрээний 4.1-д заасан үүргүүдийг биелүүлээгүйгээс үүссэн аливаа хохирлыг өөрөө бүрэн хариуцна.
- 7.4. Цахим банкны үйлчилгээ нийлүүлэгч байгууллага, үүрэн телефон операторын буруутай үйл ажиллагаа болон үйлчилгээний вэб хуудсанд холбогдоход сүлжээний саатал, эсвэл Харилцагчийн холбогдох буй компьютер, гар утсанд байрлаж буй програм, вирус зэрэг Банкнаас үл хамаарах шалтгаан, нөхцөл байдлаас үүдэн Харилцагчид учирсан аливаа хохирлыг Банк хариуцахгүй.
- 7.5. Цахим банкны үйлчилгээнд холбогдоход аль болох нийтийн сүлжээ, төхөөрөмжийг ашиглахгүй байхыг Банк анхааруулж байгаа бөгөөд үүнээс үүдэн гарах хохирлыг Банк хариуцахгүй.
- 7.6. Харилцагч мэдээллийг буруу оруулж гүйлгээ хийсний улмаас Харилцагчид учирсан хохирлыг Банк хариуцахгүй.

Найм. Бусад зүйл

- 8.1. Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж, гэрээг цуцалснаар буюу гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно.
- 8.2. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож, нэмэлт гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ.
- 8.3. Цахим банкны үйлчилгээгээр дамжуулан Харилцагч өөрийн нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг, нэг удаагийн нууц үгийг ашиглан Банкнаас санал болгож буй гэрээний нэмэлт, өөрчлөлтийн төслийг зөвшөөрсөн үйлдэл хийснээр уг нэмэлт гэрээнд гарын үсэг зурсантай ижил хүчин төгөлдөр тооцоо.
- 8.4. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөж журмаар шийдвэрлэх ба зөвшилцөж эс чадвал маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 8.5. Гэрээг хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй.

Гэрээ байгуулсан,

Банкийг төлөөлж: _____ Харилцагчийг төлөөлж: _____
 (Харилцагчийн үйлчилгээг хариуцсан ажилтны нэр) (Овог, нэр)

 (гарын үсэг), (тэмдэг) (1-р гарын үсэг), (тэмдэг)

 (2-р гарын үсэг)